



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 6 сарын 9 өдөр

Дугаар 5/36

Чингис хот

Б.Мөнхжаргалыг туршилтын хугацаагаар
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, Засгийн газрын 2007 оны "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 354 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, 2014 оны "Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай" 332 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 45 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Үйлдвэр, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлого хариуцсан мэргэжилтнээр Бөхчулууны Мөнхжаргалыг 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн туршилтын 6 сарын хугацаагаар томилсугай.

2. Б.Мөнхжаргалын цалинг ТЗ-5-1 шатлалаар тогтоон үндсэн цалин 509948 /таван зуун есөн мянга есөн зуун дөчин найман/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Үйлдвэр, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлого хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Мөнхжаргалд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР